

УДК 39

ХОРЧИН МОНГОЛЧУУДЫН ТӨРЛИЙН ТОГТОЛЦООНД ГАРСАН ЗАРИМ ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ (ӨВӨР МОНГОЛЫН ТУНЛЯО ХОТЫН ХОРЧИН ЗҮҮН ГАРЫН ДУНД ХОШУУНЫ ШИБАХУА БАЛГАСНЫ БАЯНТАРИА ГАЦААНЫ ЖИШЭЭГЭЭР)

Хуягт Ч. Мөнхтөр

Монгол улсын Соёл, урлагийн их сургуулийн докторант

Ulaanbaatar, Mongolia

E-mail: munkhturchimedbavuu@gmail.com

Агуулгын товч

Энэхүү өгүүллийг зохиогч БНХАУ-ын ӨМӨЗО-ны Тунляо хотын Хорчин зүүн гарын дунд хошууны Шихауа балгасны Баянтариа гацаанд 2015-2017 онд хийсэн хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан туурвилаа. Тус өгүүлэлд ӨМӨЗО-ны зүүн хэсэгт орших тариалангийн аж ахуй эрхлэх, хятад соёлын нөлөө нэлээдгүй хүртсэн хорчин монголчуудын ураг төрлийн тогтолцоо хийгээд төрөл садны дуудлагын өөрчлөлтийн тухай өгүүлэх болно. Удам угсаа, ураг төрлийн тогтолцоо нь тодорхойлоход маш хэцүү тул маш сонирхолтой судалгааны объект юм. Материалыг хамгийн албан ёсны тайлбараар системчлэх нь илүү алс холын ирээдүйн асуудал юм. Зохиогч энэ удаад судлаачдын дүгнэсэн ураг төрлийн тогтолцооны утга учир, чадамжийн тухай гурван талт дүгнэлт (1. Харьяалах ай; 2. Эрх ашиг, үүрэг хариуцлага; 3. Үйл ажиллагаа)-ийн харьяалах ай (нэрийдэл болон хуваарилалтын аргыг бүрэлдүүлж, хүмүүсийн орчин тойрноо биечлэн ойлгох болон ойлгоход ойлгогдохууны загвар болдог)- н асуудлыг хорчин монголчуудын жишээн дээр шинжлэхийг оролдов. Тус өгүүллийг уншигч хэн бүхэнд ойлгомжтой байлгах үүднээс ХХ зууны эхэн хагасын Өвөр монголын цахрын ураг төрлийн тогтолцооны схем зургийг өнөөгийн хорчины ураг төрлийн тогтолцооны схемтэй зэрэгцүүлэн оруулав.

Түлхүүр үг

Хорчин монгол, тариалах орон, төрөл садан, ураг төрлийн тогтолцоо, хувиралт.

UDC 39

ABOUT SOME CHANGES IN THE KINSHIP SYSTEM OF KHORCHIN MONGOLS (ӨВӨР МОНГОЛЫН ТУНЛЫАО ХОТЫН ХОРЧИН ЗҮҮН ГАРЫН ДУНД ХОШУУНЫ ШИБАХУА БАЛГАСНЫ БАЯНТАРИА ГАЦААНЫ ЗHИСHEEGEER)

Huyagt Ch. Munkhtor

Doctoral student of Mongolian University of Culture and Arts

Ulaanbaatar, Mongolia

E-mail: munkhturchimedbavuu@gmail.com

Annotation

This article was written by the author based on the original materials of the field research conducted in 2015-2017 at the Shibahua Ruins Bayantaria Gorge, Horqing Left Hand Cape, Tongliao City, China's National Autonomous Region. The article will talk about the kinship system and the change in the pronunciation of the relatives of the Khorchin Mongols, who are engaged in farming in the eastern part of the Republic of Kazakhstan, and have been greatly influenced by Chinese culture. Genealogy and kinship systems are very difficult to define and are very interesting objects of study. The systematization of the material in the most formal description is a matter for the more distant future. This time, the author made a tripartite conclusion about the meaning and capabilities of the kinship system (1. Fear of belonging; 2. Rights and responsibilities; 3. Activity) about the meaning and capabilities of the kinship system, which was evaluated by the researchers. tried to analyze the problem of understanding and being a model of what is understood in understanding) on the example of Khorkhin Mongols. In order to make the article understandable to all readers, the diagram of the kinship system of Inner Mongolia in the first half of the 20th century is included alongside the diagram of the kinship system of the present day.

Key words

Khorchin Mongol, cultivation country, kinship, kinship system, transformation.



УДИРТГАЛ

Аливаа овог аймаг, улс үндэстэн, угсаатны бүлгийн хувьд ураг төрлийн тогтолцоо нь тухайн нийгмийн суурь болж хувь хүн хийгээд бүлэг хоорондын харилцаа түүнд хамаарах үйл ажиллагааны зарчмыг тогтоож өгч байдаг. Тиймээс нийгмийн шинжлэх ухааны бүхий л салбарт чухлаар тавигддаг судлагдахууны нэг юм. Өөрөөр хэлбэл ямар нэгэн зарчмаар хэн нь “би” хэмээх хувь бодгалийн ямар хүн болохыг тогтоох агаад “би”-ийн ураг төрөлдөө хамаарах үүргээ биелүүлэхийг шаардахын сацуу “би” тэднээс юу хүсэх тэр нэгэн эрх үүргийн эш ёсны үндэслэлийг хангаж өгч байдаг.

Нийгэм соёлын хүн судлалд ураг төрөл гэдэг нь соёлын холбоо хамаарал, түүхийн гарал угсаа, аль эсвэл биологийн үе удмын үүслийг нэрлэсэн харилцаа юм. Ураг төрлийн тогтолцоонд хүмүүсийн ураг удам, бусадтай төрөл садан болсон харилцаа, гэрлэлт, биологийн “дадал”, гэр бүлийн гишүүдийн үүрэг, зэрэглэл, өв залгамжлал гэх мэт маш өргөн хүрээг хамруулан авч үздэг. Ураг төрлийн энэхүү харилцаан дээр маш олон нийгмийн бүтэц суурилагдаж байдаг. Тийм ч учраас аливаа нийгмийг бүхэллэг цогц байдлаар авч судлахыг зорьдог нийгэм соёлын хүн судлалын хувьд энэ салбар нь ихээхэн чухал байдаг гэж хэлж болно.

Монголын ард түмний ураг төрлийн тогтолцоог нэг бус удаа авч үзсэн (Omakaeva, Burykin, 2002; 2007). Монголчуудын ураг төрлийн тогтолцооны хувьсалтыг судлах нь бүхий л Өвөр монголын нийгэм соёлын хувьсалт буюу хэлбэрийн жимийг ойлгоход хамгийн том огтлоос болдог. Хагас зуунаас нааш Өвөр монголын монголчуудын ураг төрлийн тогтолцоо нь ихээхэн хувьсалтыг өнгөрүүлж, гол илрэл нь монголчуудын садан төрлийн дуудлага харьяалагдах ай болон бусад нийгэм соёлын утга агуулга нь мэдэгдэм хувиралт гарсан байна¹.

Тэгвэл ӨМӨЗО-ны зүүн орны монголчууд нь энэхүү хувиралтад хамгийн их явагдсан бөгөөд ураг төрлийн тогтолцоо, хийгээд төрөл садны дуудлагын хувьд малжих орныхоос нэлээдгүй ялгаатай болсон байдаг. Миний судалгаа хийсэн ӨМӨЗО-ны зүүн хэсэг бол XIX зууны сүүл XX зууны эхэн үеэс эхлэн тариалангийн соёлд шилжсэн. Нийгэм соёлын хувьд нэлээд сонирхолтой тариачин монголчууд голлон суудгаараа онцлогтой юм.

Антропологийн оролцон судалгаа явуулсан гол хэсэг болох Баянтариа гацааны суугуул иргэдийн дийлэнх нь XIX зууны сүүлээр хуучнаар Өвөрмонголын Зостын чуулганы Аохан, монголжин, харчин (одоогийнхоор Лионин мужийн Фүшинь сянь) зэрэг газруудаас 1891 онд гарсан Улаан алчууртны бослого² (金丹道起义 Жинь

¹那顺巴依尔。“内蒙古牧区亲属制度变迁研究”。-//“中央民族大学学报智学社会科学版”。2005年第1期第32卷。总第158期。

²1891 онд Зостын чуулганы Аохан вангийн тахилгатай уулнаас хятад тариачид мод огтолсныг Аохан ван шийтгэн мод огтолсон тариачныг ялалснаас үүдэн хятад тариачид вангийн ордныг галдан шатааж, монголчуудыг хүйс тэмтэрнэ гэсэн уриатайгаар эхэлжээ. Түүхэнд “улаан алчууртны бослого” гэж нэрлэх бөгөөд Бумбын суртахууны номлолтой шашны нууц бүлгийн турхиралтаар өдөөгдсөн бослого хөдөлгөөн. Бослогод оролцогчид толгойгоо улаан алчуураар боож байснаас монголчууд улаан алчууртны бослого гэж нэрлэсэн бөгөөд хятадаар “Жин дан дао 金丹道” гэнэ. Чингийн төрөөс хүч хэрэглэн дарсан бөгөөд уг бослогын хөлд зостын чуулганы олон монголчууд өртөн хядуулж хэсэг нь нутаг орноо орхин дайжжээ.

дан даогийн бослого)-ын улмаас уугуул нутгаасаа дүрвэн гарч Жирмийн чуулганы Хүрээ хошуугаар дамжин тус газар болох Хорчин зүүн гарын дунд хошуу (Дархан хошуу)-нд нүүдэллэн ирсэн цагаач иргэдээс бүрдсэн байна.

Тиймээс энд 30 гаруй овог угсааны хан хятад, монгол үндэстнээс бүрдсэн тосгон юм. Гэвч энд нийт хүн амын 100-ны 90 гаруй хувь нь өөрийгөө монгол хүн гэх бөгөөд цөөн хэдэн хан үндэстэн гэр бүл, хувь хүмүүс суудаг. Одоогоор өөрийн биеэ монгол гэх боловч уг гарлаа хан хятад гэдгийг мэдэх хүмүүс ч цөөнгүй байна.

Хээрийн судалгааны явцад нийт хүн амын дунд явуулсан ураг удам, хувь хүний амьдралын аман түүхээс тус тосгоны хүн ам нь

1. Шаньдун мужаас гаралтай харчин, монголжинд ирж суурьшин монголжсон хан хятад үндэстний үр сад,

2. Харчин, монголжины уугуул монголчууд,

3. Уг хорчин нутгийн монголчууд гэсэн томоохон гурван бүлэг хүмүүсээс мөн цөөн тооны манж гэгийн харьяат монголжсон манж гаралтай хүмүүс гэсэн дөрвөн бүлгээс бүрэлдсэн болох нь харагдана.

Баянтариа тосгоныхонтой уулзаж ярилцах явцад тэдний нийгэм соёлын хувиралтыг 1891 оны үйл явдал, 1949 он буюу БНХАУ байгуулагдсан, 1978 он буюу бүх улс даяар өөрчлөлт шинэчлэлт явагдсан гэхчлэн ерөнхийд нь зааглаж болох ч ураг төрлийн тогтолцоонд томоохон өөрчлөлт авч ирсэн үйл явдлуудад нэгдэлжих хөдөлгөөн, төлөвлөгөөт төрөлт, газар шорооны хувьчлал, хотжилт эрчимжсэн үе гэх зэргийг чухалчлан авч үзүүштэй юм.

ОЛОН СОЁЛТ ГЭР БҮЛ, ТОСГОН ҮҮССЭН БА ТӨРӨЛ САДНЫ ДУУДЛАГАД ӨӨРЧЛӨЛТ ОРСОН НЬ

Хорчин монголчуудын ураг төрлийн тогтолцоонд одоогоор идэвхтэй хэрэглэгдэж буй төрөл садны дуудлагын нийт 120 орчим нэр үг байгаагийн 70 хувь буюу 84 нь хятад үг, 30 хувь буюу 36 нь монгол үг байна. Үүнээс гадна “би”-ийн нэгдүгээр үе, “би”- ээс дээш, дооших хоёрдугаар үе дотроо монгол нэр дуудлага голлох бол дээш дооших бусад үеүдэд хятад нэр дуудлага голлоно. 35-80 насны 50 хүнээс авсан судалгааны асуулгаас харахад өөрөөс дээш 5-н үеийн төрөл садны дуудлагын нэр томъёог хэлж мэдэх боловч эцгийн талын өөрөөс дээш 3-н үеийн дээдсийн нэр зарим нь амьдралын түүхийг ярьж чадаж байв. Харин өөрөөс доош 4-н үеийн төрөл садны дуудлагын нэр томъёог идэвхтэй хэрэглэж байна. Чухам юуны улмаас ийнхүү хорчин монголчуудын ураг төрлийн тогтолцооны ангилал зүйд хятад үг давамгайлах болсон бэ? гэх асуулт хэн хүний сонирхлыг татах нь зүйн хэрэг биз ээ. Бид судалгааны явцад оролцогч бүрийн өөрийн болон өөрөөс дээш үеийнхний амьдралын түүхийг нэг бүрчлэн хүүрнүүлсний дотор энэхүү асуултын учгийг гаргаж болох олон эш баримт гарч байсан юм.

Баянтариа гацааны монголчуудын хувьд ураг төрлийн тогтолцооны ангилал зүйд нэлээд эртнээс хувирсан байдал ажиглагдах бөгөөд анх Аохан, Харчин, Монголжин, Түмэдэд байх үеэс эхлэн олон соёлт гэр бүлүүд, олон үндэстний нийгэм соёл бүхий тосгон сууринууд буй болж байсан тухай настайчуудын аман түүхэнд дурдагдаж байна.

Овог: Жоу нэр: Багана 67 настай. Баянтариа гацааны Бага сургуулийн захирал. Манай ло жоу жи¹ зуун омогтны хамгийн тэргүүн овог юм. Миний дээдэс одоогийн Шаньдун мужаас гаралтай хятад хүмүүсээс Дундад улсын зуун овогтон эрт дээр үеэс эхлэн дөрвөн удаагийн том нүүдэл хийсэн гэдэг. Тэр болгон нь дээрэм тонуул, дайн байлдаан, өлсгөлөн тонуулаас болж хийж байсан байна. Манай дээдэс Шаньдун мужийн Дунгуан сяниас уг нутагт нь тариа ургац алдаж өлсгөлөн гачиг тохиолдоод дамнуураар нүүдэллэж Харчинд ирсэн гэдэг. Тэнд өнө шимлэг тул арвин ургац авч бэртэй болоод хэдэн үе суугаад мөн тэр хунгас хулгай ихсээд тэндээс манай Таеэ²-ний үед Хүрээ хошуунд ирж суусан. Тэгсэн манай Езеэ³ хар тамхинд хордож амьдрах аргагүй болоод бүр аймгаараа ганц үхэртэй арчуураараа⁴ дамнуур хийж энэ нутагт аймгаараа дамнуураар ирсэн гэдэг. Тэгэхэд энэ айл Охин тэнгэрийн сүм⁵-ийн тариан тов дээр үүссэн тавхан аймгаас бүрдсэн шо шоди⁶ айл байжээ.

Дээрх жишээнээс гадна профессор Боржигин Бүрэнсайн зүүн орны монголчуудын ургийн бичиг, сүмийн данс, архивын баримтад тулгуурлан судлаад Чингийн эзэнт гүрний эхэн үед хятад хүн урт хугацаагаар гадагш гарч хөлсний ажил хийж тариа хагалбарлаж амьдрах нь харьцангуй тогтвортой байсан. Хаврын улирал ойртоход цагаан хэрэм давж Зостын чуулганд ирж тариалж, намар хураасны дараа хураасан хүмүүс нэг хэсгийг нь тухайн газрын монгол ван, гүнд тушааж өгөөд нутаг буцдаг байснаа сүүлдээ тус нутагт шингэн үлдэж байсан тухайд: Өвөр монголын өмнө хэсгийн газар нутгийн хөрсний чанар сайн ба дотор газрын хятад хүний орон нутагтай харьцуулахад газрын түрээс бага. Эдгээр нь хятад хүний сэтгэлийн татах тун таатай хүч юм. Иймээс жилийн зун нэг жилд ирж тариалах хятад хүмүүс улам олон болсон. Өөр нөгөөтээгүүр монгол ван гүн, тайж нарт ирж газрын түрээсэнд бэлэн мөнгө төлнө гэж хэлнэ. Иймээс эдгээр хятад хүмүүсийг маш таатай хүлээн авна. Ван гүнгүүд нөгөө талд тэдний дотроос хөдөлмөрч чадвартай хүмүүст нь орогнол олгох, туслах, бүр тэднийг урт хугацаагаар оршин сууж монгол болох боломж бололцоог олгож байсан. Тэр тодорхой хэрэглэх арга замын нэг нь бол эдгээр хятад хүмүүс болон монгол хүн ураг бололцох харилцаагаар монгол хошууны данс хараанд орно. Монгол хошууны данс хараанд орж одоо хуулийн дагуу тэдний үндэстнээ больж монгол хүн болно⁷. Мөн Хуан⁸ Люжин гэх хүний гэрт хадгалагдаж буй жиатинг (угийн бичиг)⁹ нь нийт 6-н үеийн хүмүүсийн нэрсийг дээрээс доош цувруулан

¹老赵氏 (laozhouzhi) Бүх Жоу омогтон гэсэн утгатай үг. Хан хятад үндэстнүүд зуун омогтны гэр бүл(百家姓) – ээс бүрэлдсэн гэж үздэг ба эртний улсуудын хаадын омог нь жоу(赵) омог тул зуун омогтны тэргүүлэх омог гэж үздэг. Энэ ойлголт хорчинчуудын дунд ч нутагшсан байдаг бөгөөд нийт 100 овогтны 7-н монгол овог байдаг гэж ойлгоно.

²太爷 Элэнц өвөг гэсэн хятад үг.

³爷爷 Өвөө гэсэн хятад үг.

⁴Тариа тарихад хэрэглэдэг багаж. Тариан талбайд шуудуу гаргах, үр булах зэрэгт ашигладаг.

⁵Зүүн орны монголчуудын дунд лоёо бурхан шүтэх ихэс дээдсүүд нь бурхны шашны сүмээс гадна лоёо бурхны сүмийг зэрэг тахиж байсан байдаг. Жирэмийн чуулганы Хорчин зүүн гарын дунд хошуунд байсан лоёо бурхны сүм.

⁶Цөөн өрхөөс бүрдсэн багахан айл. 小小的 бага, жижиг гэсэн утгатай хятад үг

⁷著. 李儿只斤. 布仁赛音. 泽. 娜仁格日勒. “近现代蒙古人: 农耕村落社会的形成”. 2007 年. 内蒙古大学出版社. 页 161-162.

⁸Энэхүү Хуан овог нь монголжинд байдаг шарнууд овгийг хятад үсгээр 黄 гэж тэмдэглэснээр өдгөө хорчинд хуан, ян гэхчлэн дуудагдах болсон байна.


⁹Монголчуудын хувьд нийгмийн дээд давхаргын буюу Чингисийн угсааны ноёд тайж нарын угийн бичиг гол төлөв байдаг авч жирийн ардын дунд угийн бичиг хөтөлж байсан баримт тун хомос юм.

бичсэн байх бөгөөд үе болгоныг тодотгон сутайеэ (苏太爷 sutaiye), таеэ (太爷 taiye), ееэ (爷爷 yeue), баба (爸爸 baba) гэхчлэн урд нь бичсэн байв. Тус ургийн бичгийг 1980-д оны үед түүний аав бичсэн байна. Гэвч энд онцлууштай нь урьд нь тус гэр бүлийн жиатинг байсан бөгөөд соёлын хувьсгалын үед хураагдан шатаагдсан бөгөөд түүнийг яг байснаар нь түүний аав сэргээхийг оролдсон тухай бидэнд өгүүлсэн юм. Энэ мэтчилэн олон соёлт гэр бүлүүд олширсон мөн түүнчлэн нэг тосгонд хятад монгол айлууд холилдон суух болсноор дан ганц төрөл садны дуудлагаар зогсохгүй олон талын хувиралт гарсан нь байна. Энэ тухай XX зууны эхэн хагаст зохиол бүтээлээ туурвиж явсан Лувсанчойдон ч ном¹-ынхоо олон газар дурдсан байдаг.

Дээрх мэдээнүүдээс Чин улсын сүүл үеэс гэхэд одоогийн Баянтариа гацааныхны өвөг дээдсийн төрөл садны дуудлага өнөөгийн хэв шинжийг олох үндэс бүрдсэн байна гэж үзэж болохуйц байна.

Хорчин монголчуудын төрөл садны дуудлагад харь гаралтай үг нэвчих болсон хамгийн том шалтгаан нь тэдний аж ахуй нь тариалангийн соёлд шилжсэнтэй зайлшгүй холбоотой болно. Тариалангийн соёлын нэг онцлог нь гэр бүл ураг төрлийн гишүүн бүрийн ажил үүргийн хувиар маш тодорхой байхаас гадна гэр бүл эдийн засгийн үндсэн холбоог чухалчилдаг тул гэр бүлийн гишүүдийн үүрэг роль тодорхой байхаас гадна тэдний төрөл садны дуудлага ч хувь бодгаль бүрийг цохсон шинжтэй хүйс зэрэг дэвийг тодорхой заасан утгатай дуудлага нэр байдаг. Суурин соёл иргэншилтэй ард түмний хувьд хөдөө аж ахуйд түшиглэсэн эдийн засгийн сонгодог хэлбэр нь их гэр бүл бөгөөд их гэр бүл нь нэгэн төрлийн эдийн засгийн хамтрал юм. Гэр бүлийн гишүүд гэр бүлийнхээ орлогын төлөвлөгөө, өв хөрөнгө, эдийн засагт захирагддаг агаад гишүүн бүрийн үүрэг хариуцлага тэр бүү хэл нэр дуудлага бүр түүнд тохирсон ялгамжтай байдаг (Юньсян, 2015: 1-2). Өөрөөр хэлбэл хувь хүн нэг бүрийн тухайн үе удмыг нэрлэсэн нэр нь хүйсээ давхар зааж байдагт оршино.

Өнөөгийн хорчины ураг төрлийн тогтолцооны зураг




Харин хан хятад хүмүүсийн хувьд жиафу буюу угийн бичиг хөтлөх явдал өрх бүрд нэлээд түгээмэл юм. Энэхүү соёлын нөлөө хорчинд нөлөөлсөн бололтой.

¹Лувсанчойдон. Монгол зан айлын ойлбор. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо. Хөх хот. 1981. 39, 41, 42 зэргээс дэлгэрүүлж харна уу.

Энэхүү схемийг бүх үеийн хүмүүс нийтлэг мэдэж, хэрэглэж байгаа төрөл садны дуудлагыг голлон зохиосон болно.

XX зууны эхэн үеийн Цахрын ураг төрлийн тогтолцооны зураг (Насанбаяр 2005)



**УРАГ ТӨРЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭГ ТОГТООСОН
ТӨРӨЛ САДНЫ ДУУДЛАГЫН ТУХАЙД**

Монголчуудын дунд байдаг нийтлэг ойлголтын дагуу хорчинчууд эцгийн талыг ясан төрөл, эхийн талыг махан төрөлд хамааруулан ойлгох ба ураг төрлийн харьяаллын айд багтах дээдэс, нэг угсаа, хамаатан, ойр төрөл, садан төрөл, ахан дүүс, төрлийн эгч дүү, нэг аймаг, нэг омогтон, омгийн ахан дүүс, бүл, авга ач, нагац зээ удам угсаа хэмээх төрөл садны дуудлагыг идэвхтэй хэрэглэсээр байна. Гэвч эдгээр үгсээс тодорхойлон харьяалах айн хувьд нэг омгийнхон, омогтон, хамаатан, садан төрөл, ахан дүүс зэрэг нь илүү өргөн хүрээг хамарч тухайн хүний өөрийн амьдарч буй болон өөрөөс дээш, дооших бүх үед эгээ л нэг янзаар хэрэглэж болох бол харин дээдэс нь өөрөөс дээших өнгөрсөн цаг үеийнхнийг заахын сацуу нэг овгийн босоо шугамын дагуух хүмүүс багтах агаад ихэвчлэн эр хүйсийг чухалчлан заадаг онцлогтой ажээ. Энд ураг төрлийн тогтолцооны зааг шугам, хил хязгаарыг тогтооч хүч нь омог буюу овогт илүүтэй төвлөрнө.

Нэг өрх амд харьяалагдах хүмүүсийн хувьд бусад газрын монголчууд(баруун буюу малжих орон, монгол улсын)-аас ялгаатай тал нь эцэг эхээсээ хэдүүлээ вэ? Гэсэн асуултад нэг эцэг эхээс төрсөн эмэгтэй эрэгтэй ах дүүсийгээ хүйсийн айгаар салган ах дүү(энд зөвхөн эрэгтэй дүүг оруулна) тэд, эгч дүү(зөвхөн эмэгтэй дүүг оруулна) тэд, эгч дүү хоёр би өөрөө нийлээд гурвуул, нэг эгч хоёул гэхчлэн онцгойлон хүйсийн айгаар ялгаж хэлнэ. Мөн энэ мэтчилэн их гэр бүлээрээ амьдарч буй тохиолдолд есээ, найнай, аава ээж, ач, ач охин, зээ үү, зээ охин тэдүүлээ гэхчлэн нэрлэх агаад нэг эцгийн гурван хүү бие биеэ дагө (大哥 том ах), ергө (二哥 хоёрдугаар ах), шогө(小哥 бага ах, отгон хүү) гэхчлэн эрэмбэ дараалан авгайлна. Эмэгтэй хүүхдүүд бол хамгийн томоо их жэйжэй, бага жэйжэй, эмэгтэй дүүгээ мэймэй эсвэл дүү, дүүдэй, охин дүү гэхчлэн өөр хоорондоо дуудна.

Гэр бүлийн гишүүдэд хүргэн, бэрийг оролцуулан дуудахдаа хүү-бэр, хүргэн-охин, тэдэн хүргэн, тэдэн бэр гэх ба ло бэр(их хүүгийн бэр), шо бэр(бага хүүгийн эхнэр) гэж ялгамжлахын сацуу ерөнхийд нь шо бэрүүд, шо ангаа нар, нэг айлын хүргэн,

бэрүүд гэхчлэн ярина. Нэг айлын хүргэгчүүд “баз”-ууд болох ба хоорондоо бие биеэ лианчуар гэж дуудна. Харин хүргэн, бэрүүд гуя баз болно. Хоёр бэр бие биеэ авьсан, ажин хэмээн дуудаж ахмадыгаа авьсан жэйжэй (姐姐), багыгаа дүү бэр, бэр дүү гэж дуудах нь элбэг ажээ.

Харин нэг гэр бүлийн эхнэр нөхөр хоёр бие биеэ манай гэрийн хүн, манай хүн, эхнэр нь нөхрөө данжиад, лаогүн (老公) харьцангуй настай гэр бүл бол лотур гэж дуудна. Нөхөр нь эхнэрээ өтөлсөн хүмүүс бол хөгшин, лаофо (老婆), энхэр гэх ба сүй тавьсан хосууд бол дүйшэнь (对生) гэнэ.

Авга талын ах нарын эхнэрийг ерөнхийдөө “шинсө” гэх ба аавын том ахын эхнэрийг “да мөөм”, аавын эмэгтэй дүүгийн нөхрийг “гуяа аав” гэж дуудна. Аавын эрэгтэй, эмэгтэй дүү нарын хүүхдүүд бол гүгү (姑姑), жүжү (舅舅)-ний хүүхдүүд буюу гүжүчин, хоёр эмэгтэйн хүүхдүүд инанчин болдог байна.

Ээжтэйгээ нас ойролцоо төрлийн болон төрлийн бус эмэгтэйд инанга, шинэсө гэж ч дууддаг. Эсрэгээрээ ээж, аав нь эсвэл аав ээжийнх нь үеийн хүмүүс бага залуу хүмүүс болон хүүхдүүдийг анга, шо анга хэмээнэ.

Хорчинчуудын төрөл садны дуудлагын дунд монгол-хятад холбоо үгээр илэрхийлсэн нэр нэлээдгүй байна. Үүнд: нага тайеэ, нага тайтай, нага есээ, нага найнай, нага аав, нага мөөм, нага жэйжэй гэхчлэн өөрөөс дээш үеийнхнийг дуудах дуудлагад монгол-хятад холбоо үг голлож байна. Харин “би”-ээс дооших үеүдэд голчлон монгол дуудлага зонхилох бөгөөд ач бэр, ач хүргэн зэрэг үгнүүд сүүлийн үед хэрэглэгдэх нь багассан байна. Энэ тухай: Ганц хүүхэд аваад түүнийгээ хот руу сургуульд явуулж бичиг үзүүлэх болсноор манай энд өөрөөс доош, дээших үеийн төрөл саднаа мэдэх хүн ховор болж байна гэсэн настны халагласан яриа ч олонтой тохиолдож байв¹. БНХАУ-д төлөвлөгөөт төрөлтийн бодлогыг авч хэрэгжүүлсний улмаас өвөр монголчууд нэг юм уу хоёр хүүхэдтэй болох болж тэр нь гол төлөв эрэгтэй хүүхэд төрүүлэхийг эрмэлзэх болсноор ураг төрлийн тогтолцооны олон салбаруудад хувиралт өөрчлөлт гарсаар байгааг энд дурдах нь зүйтэй байна.

БЭЛГЭДЭЛ ЗҮЙРЛЭЛЭЭР БУЙ БОЛСОН УРАГ ТӨРӨЛ БА ДУУДЛАГА

Дэлхий дээр аль ч ард түмэнд өөр өөрсдийн соёлын онцлогтойгоор төрөл садан бололцдог бэлгэдэл зүйрлэлийн ураг төрлийн тогтолцооны хэлбэр түгээмэл оршин байдаг. Хүүхэд өргөж авах, ах дүү бололцох, анд барилдах, христосын шашинтнуудын дунд загалмайлсан эцэг гэх мэт. Тэгвэл энэ төрлийн ураг төрлийн тогтолцооны хэлбэр олон газрын монголчуудын дунд ч нийтлэг болоод газар орон, угсаатны бүлгийн онцлог ялгаатай эртнээс нааш байсаар ирсэн. Бид энд хорчин монголчуудын бэлгэдэл зүйрлэлээр ураг төрөл болох зан үйл, төрөл садны дуудлага онцлогийн тухай Баянтариа гацааг жишээ болгон товч өгүүлсүү.

а. Зуун овогтны гэр бүл, зуун овогтон гэсэн ойлголт хорчинчуудын дунд түгээмэл яригддаг уг зуун овогтон гэх ойлголт бол хан хятад соёлоос орж ирж нутагшсан соёлын элемент юм. Үүнтэй холбоотойгоор зуун омогтны ахлах омог нь жоу дараа ли, ван, хан гэх мэт овгууд ордог бөгөөд зуун омогтны гэр бүлд 7-н монгол

¹Лю Лунмэй. Нас: 67, эмэгтэй. Баянтариа гацааны тариачин. 2015 оны 2-р сард хийсэн ярилцлага.

омог багтдаг гэсэн ойлголт нэлээд түгээмэл тархжээ. Энэ ойлголт зуун омогтноос бүрэлдсэн жунгуо гэсэн их гэр бүл эв найртай амьдрах ёстой гэсэн үзэл суртлын ойлголттой нягт холбоотой ажээ.

б. Ах дүү барилдах, цусаа уусан ахан дүүс энэ ёс нь өөрийн үе зэргийн хүмүүстэй эе найртай явахаар тохиролцон зарим онцгой үед тангараг тавин ах дүүгийн барилдлага тогтоодог ажээ. Гэвч энд садан төрөл дотроосоо эсвэл дээдэс нь хоорондоо өстэй хүмүүс ах дүү бололцохыг цээрлэдэг. Хоёр хүн хэдэн ч удаа ах дүү барилдаж болох бөгөөд гурван удаа ах дүү барилдсан хүмүүс төрснөөс ялгаагүй болдог гэсэн хэлц ч байдаг. Ингэхдээ тодорхой зан үйл үйлдэх ба аль ахмадынхаа гэрт очиж Лоёо бурхан¹ тахиж, лоёо бурхны өмнө амандаа хутга үмхэж сөгдөн тангаргална. Энэхүү зан үйл нь хорчинчуудын дунд тархсан хуурын үлгэрээр дамжин нутагшсан байх талтай ажээ. Учир нь “Гурван улсын үлгэр” хэмээх хятад үлгэрт гарах нэгэн домгоос үүдэлтэй бөгөөд Лоёо бурхныг тус үлгэрт гарах Гуан гүн баатрын хувилгаан дүр хэмээн итгэдэг байна. Тус үлгэрт Гуангүн, Жанфэй, Любэй хэмээх гурван хүн ах дүү барилдаж журмыг сахин, их үйл бүтээдэг тухай гардгаас үлгэр аван ах дүү барилдах ёс үүсжээ хэмээн ярих хүмүүс ч олон таарч байв. Ах дүү барилдахдаа:

Нэг л амьтай адил явж

Нэг зоос байвал хамтаар зарж

Нэг морь байвч хамтаар унан

Нэг нь нэгэндээ муу санаа гаргаж журмыг тэрсэлж, тангаргаа эвдвэл Лоёо бурхан мань тангаргалсан ёсоор үзүүлтүгэй гэж барьж тангаргалсан юмаа үзүүлэх бөгөөд архинд эрхий хурууны өндөгний цусыг дусаан амсацгаана (Хүрэлбаатар, Уранчимэг, 2012: 79).

Ийнхүү тангараг тавьсны дараа архи ууж найралдаг уламжлалтай ажээ. Энэхүү бэлгэдлийн зан үйлээр ураг төрөл бологсдыг тангараг тавьсан ах дүүс, журмын ах дүүс, гэхчлэн нэрлэх явдал ч байна.

в. “Мөргүүлсэн аав, ээж” ураг төрлийн энэхүү хэлбэр нь хуримын зан үйлтэй холбогдон бий болох бөгөөд хүүдээ бэр авах гэж буй хүн хуримын өдрөөс өмнө өөртэйгөө нас ойролцоо, нутгийн төлөв төвшин, элэг бүтэн ивээл жилтэй хэн нэгнийг сонгон архи хадаг барин хүү, бэрээ мөргүүлэхээр гуйдаг байна. Хүн бүрд ихэвчлэн хоёр мөргүүлсэн аав ээж байх бөгөөд бэрийн тал ч гэсэн мөн охиндоо мөргүүлсэн аав ээж гуйна. Ингэж хэлэлцэж тогтоод хуримын өдөр хүү, бэр хоёрыг тэнгэрт мөргөх үед үсийг нь хагалж өгөөд галд мөргөх үед нь галыг нь халхална гэж цагаан алчуураар нүүрийг нь халхална. Зарим үед тэднийг халуун галыг халхалсан аав, ээж ч гэж дуудах тохиолдол байдаг аж (Хүрэлбаатар, Уранчимэг, 2012: 79). Мөргүүлсэн аав ээжийн холбоо нь сар дүүрэх, цагаан сар, насны баяр зэрэг тэмдэглэлт баяр ёслолын үед урьж залах харилцан бэлэг солилцох зэргээр ач холбогдол нь илэрдэг ч ханш, гал тахих зэрэг тахилгын үе болон бусад энгийн цагт тийм ч өндөр ач холбогдолгүй ураг төрлийн холбоо ажээ.

г. Ураг хуримын үед тогтдог бас нэг бэлгэдлийн ураг төрөл бол “таниулсан эцэг, эх” юм. хэрэв хүү, бэрийн хэн нэгний аав эсвэл ээж урьд нь нас барсан бол ойр төрөл дотроосоо ээж, аавын үе тэнгийн хэн нэгнийг сонгон аав, ээжээ орлуулан мөргөдөг.

¹Бо Бои. Нас 50, Баянтариа гацааны тариачин. 2016 оны 2-р сард ярилцсан ираны хэсгээс.

д. “Шургуулсан аав, ээж” хорчинчуудын дунд түгээмэл байдаг энэхүү ураг төрлийн тогтолцооны хэлбэр нь хүүхэдтэй холбогдох зан үйлээр дамжин төрөл садан болдог хэлбэр юм. Өөрөөр хэлбэл цусан төрлийн биш эцэг эхийг бий болгож хүүхдийн эрүүл мэндийг хамгаалж амьдрах эрх олгож буй хэрэг агаад тухайн хүүхдийн хувьд шургуулсан эцэг эхэд насан туршийн хүндэтгэлээр хариу барих үүрэг оногддог. Өвөр монголын төв болон баруун хэсэгт үүнтэй ижил хэлбэрийн ураг төрлийн тогтолцоо байх агаад хуурай аав ээж гэж нэрлэнэ (Park, 1997: 119).

Хорчинчуудын хувьд хүүхэд нь тогтдоггүй, ороолгон, энхрий хүүхэдтэй айлд хүүхэд төрөх үед айл тосгоны, эсвэл зэргэлдээ саахалт тосгоны хэн нэгэнд хүүхдээ шургуулах зан үйлийг үйлдэнэ. Энд миний ажигласан нэг сонирхолтой зүйл гэвэл гол төлөв хятад хүнтэй шургуулсан аав хүүгийн холбоо тогтоосон байх ба нутгийн настайчуудаас ямар учиртайг тодруулахад нарийн тодорхой тайлбар олдоогүй юм.

ДҮГНЭЛТ

Өнөөгийн Хорчин монголчуудын ураг төрлийн тогтолцоо, тэр дундаа төрөл садны дуудлагад хувиралт гарах үндэс нь Чин улсын сүүл үед цагаан хэрмийн араар орших Зостын чуулганд цагаачлан ирсэн хан хятад тариачид тус нутгийн монголчуудтай ураг барилдах, холилдон суурьших болсноор хятад соёлын нөлөө ихэссэнээс болж тавигдсан байна. Тийнхүү соёлын нэлээдгүй хувиралт олсон монголчууд 1891 оны улаан алчууртны бослогын үйл явдал болон бусад шалтгааны улмаас тус нутгаасаа дүрвэн Жирмийн чуулганд ирж суурьшсанаар өнөөгийн хэв шинж бүрэлджээ. Мөн түүгээр ч зогсохгүй 1949 онд БНХАУ байгуулагдсанаар олон үндэстнээс бүрэлдсэн их гэр бүлд эв найртай орших төрийн үзэл суртал соёлын олон төрлөөр дамжин ураг төрлийн тогтолцоонд ч нөлөөлсөн ажээ. XX зууны II хагасаас төрөөс авч хэрэгжүүлсэн төлөвлөгөөт төрөлтийн бодлого, орчин үеийн хотжилт зэрэг нь зарим үеийн төрөл садны дуудлагын монгол нэр мартагдах, хан хятад соёлын нөлөөнд автах явдал өдгөө ч үргэлжилж байна. Мөн үүний зэрэгцээ хорчин нутгийн онцлогтой нийгэм, эдийн засгийн ач холбогдлыг чухалчилсан бэлгэдэл зүйрлэлээр дамжин буй болдог ураг төрлийн хэлбэрүүд ч оршсоор байна.

Ном зүй

Barnard, Alan. (1994). Rules and Prohibitions: The Form and Content of Human Kinship. *Companion Encyclopedia of Anthropology*. New York and London Routledge. 783-812.

Burensain, 娜仁格日勒 (2007). 近现代蒙古人农耕村落社会的形成 = *Formation of the Mongolian farming village society*. URL=<https://api.semanticscholar.org/CorpusID:127086496>.

Khyrelbaatar, Uranchimeg (2012). *Horchiny zan yjl*. Өвөр монголын ардын хөвлөлийн хороо. Hoyor dah' hevlel. Hөh hot.

Luvsanchojdon (1981). *Монгол зан аалийн үйлдвэр*. Өвөр монголын ардын хөвлөлийн хороо. Хөх хот.

Nashun Bayir [Насанбаяр] (2005). Research on the Changes of Kinship System in Pastoral Areas of Inner Mongolia (Өвөрмонголын малжих орны ураг төрлийн тогтолцооны хувиралтын судалгаа). *Journal of the Central University for Nationalities* (Philosophy and Social Sciences Edition). 32. 1. 158. Hohhot.

Omakaeva, E.U., Burykin, A.A. (2002). Terminy rodstva mongolov i buryat. *Algebra rodstva*. 7. SPb.: Kunstkamera. 240–247.

Omakaeva, E.U., Burykin, A.A. (2007). Sistema terminov rodstva i svojstva v mongol'skih yazykah: skhodstva i razlichiya. *Mongolovedenie*. 4(1). 40–57.

Park, Hwan-Young (1997). *Kinship in Post-Socialist Mongolia; Its Revival and Reinvention* [M]. Dissertation for the Ph.D degree. Cambridge.

Юньсян, Янь (2015). *Социализмын доорх хувь хүний амьдрал: Хятадын нэгэн тосгоныхны хайр сэтгэл, дотно харилцаа, гэр бүлийн өөрчлөлт (1949-1999)*. Хятад хэлнээс орчуулсан Ч. Мөнхтуул. Улаанбаатар.

Pao, Kuo-Yi (1964). Marriage customs of a Khorchin village. *Central Asiatic Journal*. 9 (1). 29–59.